



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 385

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.2, 6.2.3, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Хөвсгөл-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1 нэрийн нийт 50,484,000.00 (тавин сая дөрвөн зуун наян дөрвөн мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Хөвсгөл-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга О.Мөнхсоёл, гүйцэтгэх захирал Б.Галбадрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, хоёрдогч түүхий эд болгон худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2020 оны 07 дугаар сарын 06-ний
өдрийн 385 дугаар тогтоолын хавсралт

**"Хөвсгөл-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

№	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиглалт ад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Сэлбэгээр худалдах, орлогод авах доод үнэ /төгрөг/
1	ДЗ-121257 маркийн автогрейдер, 57-10 УБ улсын дугаартай, Арлын дугаар 1490339	2009	50,484,000.00	1,000,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		50,484,000.00 (тавин сая дөрвөн зуун наян дөрвөн мянган)	1,000,000.00 (нэг сая)